

Монгол, манж албан бичгийн харьцаа

М.Баярсайхан (МУИС)

Ахуй амьдралын хэв маяг, эдийн засгийн хэвшил ойр төстэйн хувьд монгол, манж угсаатан, тэдний өвөг дээдэс хаяа нийлэн нутаглаж ирсэн бүхий л түүхийнхээ туршид нягт харьцаа холбоотой байсаар иржээ. Тэрхүү түүхэн бодот нөхцөл байдлын явцад эл хоёр угсаатны эд өлгийн болон оюуны соёлын зүйлс харилцан нэвтрэлцсээр ирсний дотор, бидний сэдэвт илүүтэй холбогдох төр ёс хийгээд бичгийн соёлын харилцан нөлөөлөл нь түүхийн тавцнаа төр улсаа байгуулан мандаж асан, Их Ляо улс, Алтан улс, Их Монгол улс, Манжийн Чин улсын үед түүхэн туршлага болж, харилцан уламжилж шинэчлэгдсээр ирсэн юм. Тэр бүхнийг үл өгүүлэн Чин улсын үе дэх монгол, манж албан бичгийн онцлог харилцан холбогдох тухайд зарим зүйлийг дурдая.

Албан бичиг нь тухайн цаг үеийн бичгийн хэлний хэм хэмжээ, хөгжил хувьслын байдлыг илэрхийлж, нөгөө талаар нийгмийн харилцаа, зан суртахуун, үзэл ухамсрын асуудлыг ч ямар нэг хэмжээгээр тусгасан байдаг.

Бид нэгэнтээ Монгол Манж угсаатны бичгийн хэл хийгээд төрт ёсны харилцаа холбооны асуудлыг хөндөж буй тул манжийн тулгар төр байгуулагдахаас өмнөх манж монголын харилцааны төлөв байдал ямархуу байсан талаар зохих төсөөлөлтэй байх нь зүй. Юань улс болон Умард Юань улсын үеийн Жүрчиний түүх тун бүрхэг тул тэр цагийн монгол манж угсаатны харилцааны түүх бас л тодорхой бус байдаг. Гэвч, бидэнд уламжлан ирсэн түүхийн мэдээ баримтаас үзвэл, Жүрчин нарын дунд Монголын соёл ихэд нэвтэрч байсан нь гарцаагүй байна. Үүний нуталгаа болгож цөөн жишээ дурдвал,

- Юань улс мөхсөний хойно, Мухулайн удмын Нахачу ноён Сунгари мөрний цутгал болох Дунмяохэ, Итуньхэ зэрэг голын сав орчмоор нутаглан монгол, жүрчин нийлсэн хэдэн түмэн цэргээр Мин улсыг эсэргүүцэн тэмцэж байв¹. Тэр бээр 1387 онд Мингийн хорин түмэн их цэрэг орж ирэхэд аргагүй бууж өгсөн бөгөөд Жүрчиний Хайси газрын гүн цол авч байжээ.

- Манж хэлтний нэгэн салаа салбар болох шивэй нарыг Хорчин аймаг эрхшээн захирч байв².

- Жүрчиний Гувалча аймаг мөн монголчуудын эрхшээлд байв.

- Монголын Түмэдийн нэгэн хэсэг Жүрчиний Ехэ голын³ хавь газрыг эзлэн, тэндэхийн жүрчин нартай хутгалдан сууж Ехэ улс (аймаг)-ыг байгуулсан түүхтэй.

- Ойрдын Эсэн тайш усны гурван Жүрчидийг довтолж эедээ оруулж байсныг монголын түүхийн сурвалжуудад тэмдэглэжээ.

- 1558-1592 онд Монголын төрийг барьсан Цахарын Түмэн засагт хаан жүрчин, дагуур, нэлигүд (аригуд)-ийг довтолж эрхшээж алба авч байв⁴. Цахарын Түмэн засагт хаан мөн Хойфа хэмээх жүрчин аймгийг дайлж байсан мэдээ манж сурвалжид байдаг⁵.

- Монгол Жүрчин (манж)-ий ноёд харилцан худ ураг барилцах явдал эртний уламжлалтай бөгөөд манж угсаатан бүрэлдэн бий болж байсан тухайн цаг үед Лигдан хутагт хаан, Махасамади Сэцэн хаан Шолой⁶... гэх зэргээр монголын хаад ноёд жүрчин хатантай байжээ.

“Мин-ши”, “Корё-са” зэрэг нангиад, солонгос түүхийн сурвалжид *Хададай*, *Бату буха*, *Елей төмөр*, *Даругачи*, *Баргудай*, *Мэнгэтөмөр*⁷, *Даиш* гэх мэт монгол нэртэй Жүрчин овог, аймгийн ахлагч нарын нэр, “урянха”, “хонгираг” зэрэг харьжсан монгол овог хийгээд монгол цол тушаалын нэр тэмдэглэгдсэн байдаг аж. Юань улсын болон түүний дараахан үед хятад, түрэг, солонгос, жүрчин нарын дотор монгол нэр, монгол цолыг нэр хүндтэйд тооцож, монгол нэр цол өгөх, авах явдал элбэг байв. Тэгвэл, бүр 17 дугаар зууны эхэн үед ч гэсэн манж нарын дунд монгол хүний нэр, монгол цолыг

¹ В.В.Евсюков, Чжурчжэни и их отношения с Мин.(XV.в.); Восточная Азия и соседние территории в средние века. Новосибирск 1986, 68с.

² Энэ талаархи мэдээ баримт Энх-Амгалангийн 39 дүгээр оны бүгд захирах дотоод сайдын айлтгал зэрэг манж албан бичигт буй.

³ Одоогийн Тунхэ гол бололтой.

⁴ “Эрдэнийн товч”, “Монгол боржигид овгийн түүх”, Галданы “Эрдэнийн эрхи” зэрэг сурвалжид тэмдэглэжээ.

⁵ “Дайчин улсын тулгар төр нээсэн бодолгын бичиг”-ийн 6 дугаар дэвтэрт буй.

⁶ Лигдан хааны хатан Сутай тайху бол даруй Жүрчиний Ехэ аймгийн тэргүүн Жинтайши бэйлийн ач охин бөгөөд Сутайн охин дүү нь Сэцэн хан Шолойн хатан болсон ажгуу.

⁷ Нурхачийн өвөг эцгийн нэр. Жүрчиний удирдагч байжээ.

эрхэмд үзсэн хэвээр байлаа. Манжийн хааны шадар зөвлөх бөгөөд бичгийн их түшмэлд “багш” цол өгч байв. Мөн “заргач” хэмээх тушаалтныг томилдог байжээ. Жүрчиний сурвалжтан нар өөр хоорондоо монгол цол өгч байсан баримт олон. Тухайлбал, Нурхачи өөрийн дүү нар болох Шургачи-д “Дархан баатар”, Баяара-д “Зоригт”, Мургачи-д “Чин баатар” хэмээх цол, хөвгүүддээ “Хун баатар”, “Аргат түмэн”, “Гүен баатар”, “Мэргэн дайчин”, “Эрх чөөхүр” зэрэг цол шагнаж байсан ба Нурхачийг өөрийг нь ямагт “Sure Kundulen han” (Сэцэн Хүндлэн хаан)⁸ хэмээх цолоор нь өргөн дуудах буюу бичиж байжээ.

Энэ мэтчилэн түүхийн олон мэдээ баримтаас үзвэл, эрхшээн захирч байсан болон манжижсан монголчуудын эрх нөлөө жүрчин нарын дунд их байсан нь илэрхий. Нөгөө талаас, ялангуяа Жүрчиний сурвалжтан язгууртан нар монголын соёлын нөлөөнд илүү автаж байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Манж (жүрчин) нар XIII зуунаас нааш монгол бичиг хэрэглэсээр байсан бөгөөд 16 дугаар зууны эцсээр жүрчин аймгуудад хамгийн их тархмал бичиг нь монгол бичиг байсан гэж үзэх үндэстэй юм. 1599 онд буюу Хойд Алтан улсыг байгуулахаас 16 жилийн өмнө манж нар улсынхаа бичгийг тогтоосон билээ. Эл хоёр угсаатны Юань улсын үеэс хойшхи нягт харилцаа холбоо нь манж нар төрийн бичгээ тогтоохдоо, гагцхүү монгол бичигт тулгуурлах нь зайлшгүй болохуйц хэмжээний нийгэм соёлын нөхцөл байдлыг бүрэлдүүлсэн байлаа⁹. Манжийн төр улсыг тулгар байгуулагч Нурхачи баатар “үүний урьд бидний улс урагш хойш явуулах аливаа бичгийг цөм монголын үсгээр монголын хэлээр орчуулан явуулах бүлгээ” хэмээн нэгэнтээ дурдсан байдаг.¹⁰ Жүрчин, солонгос, манж бичгийг зохиоход монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсэг үлгэр болсныг бид мэднэ. Тэгвэл, манж нарын тухайд хэлэхэд, зөвхөн үсэг бичиг төдий бус, ерөөс манжийн утга зохиол монгол хэл бичгээрхи албан бичгийн зүйлээс эхэлсэн уламжлалтай байна. Манж нарын хэлбичгийн анхны “багш нар нь” монголчууд байсан тухайд маргах зүйлгүй биз ээ.

⁸ Хөхөгчин могой жил /1605 он/ өвөр Халхын баяуд аймгийн Энгэдэр тайж халхын таван аймгийн ноёдыг тэргүүлэн Алтан улсын хаан Нурхачид тэмээ морь хүргэж мөргөхөөр очихдоо энэхүү “Хүндлэн хаан” цолыг өргөмжилжээ. Дашрамд өгүүлэхэд, Умард Юань улсын үед “Байсахал хүндлэн хаан”, “Энхэбэй хүндлэн хашха”, “Нахиа хүндлэн чөөхүр”, “Халигучины удаач хүндлэн” гэх мэтээр идэвхтэй хэрэглэж асан “kündülen” хэмээх энэ монгол цолын нэрийг “хөндлөн”, “хүндлэн” гэсэн хоёр янзаар хөрвүүлсээр иржээ. Хэрвээ манж бичгийг нь баримталбал, “хүндлэн” /kündülen/ хэмээх нь зүйтэй бөгөөд хүндтэй, хүндлэм гэсэн утга агуулж буй мэт.

⁹ Үүний сацуу, хоёр хэлний ойр төстэй байдал нь манж нар монгол бичигт дадаж, улмаар хэлэндээ тохируулан хэрэглэхэд аандаа нэгэн таатай нөхцөл болжээ.

¹⁰ 1627-1635 онд зохиогдсон “Дайчин улсын Тайцзу дээд хуандийн магад хууль”-д тэмдэглэжээ.

13 дугаар зууны үест Монголд албан бичгийг хаанд холбогдох үгүйгээр нь “*бичиг цагаан*”, “*бичиг хар*” хэмээн ялган нэрлэж байжээ. Хааны хамаатай бичгийг “цагаан”, бусад бичгийг “хар” хэмээн тодотгож байв. Хожим хэрэглэгдэхээ байж, монгол хэлнээ зөвхөн “*бичиг хар*”, “*данс хар*” гэсэн хоршоо үг үлдсэн билээ. Сонирхолтой нь бичиг хар, данс хар гэдгийн “*хар*” хэмээх үгийг манж хэлэнд “*чаган*” гэдэг. Энэ нь мөнөөх “*бичиг цагаан*” гэдгийн цагаан хэмээх үг дунд үеийн монгол хэлний дуудлага болон монгол бичиг дэх “*сауан*” гэдэг хэлбэрээр манж хэлэнд орж, улмаар ялган нэрлэж байсан нь мартагдахын хамт монгол хэлний “*бичиг хар*”, манж хэлний “*битхэ чаган*” харилцан утга дүйх болсон хэрэг юм.

Өнөөг хүртэл уламжлан ирсэн манж бичгийн хэлний хамгийн эртний дурсгал бол 1604-1635 оны манжийн төрийн чухал хэргийн тэмдэглэл хийгээд албан баримт бичгийг эмхэтгэсэн “Дусал бинтгүй үсгийн данс” (SHIU MAN TAN)¹¹ хэмээх дурсгал юм.

Тус дансанд буй манжийн албан бичгийг ажиглавал, Умард Юань улсын үеийн монгол албан бичиг үйлдэх хэв журмыг бараг хэвээр нь даган баримталж байсан нь илэрхий байна. Тухайлбал,

- Зарлигийн бичиг нь “*хааны зарлиг*”, “*хааны бичиг*”, “*хааны зарлигийн бичиг*” хэмээх үгээр эхлэн хэнд илгээж буйгаа бичжээ. Дараа нь үндсэн агуулгаа бичиж, эцэст нь огноо тавьсан байна. Монгол хэл, бичгээр зарлиг, захидал бичиг үйлдэх энэ бүтэц дараалал 13 дугаар зууны үеэс уламжилсаар манж албан бичигт нэвтэрчээ.

- Тэнгэр, хаан, бэйл, бэйс, хуанди гэх мэт үгсийг их бага ялгамжаатай мөр тэтгэж бичсэн нь монгол албан бичгийнхээс огт ялгаагүй байна.

- Ихэнх зарлигийн бичгийн хуулгад, эхэнд гарах тэрхүү “*хааны зарлиг*” хэмээх үгийг мөр тэтгэж бичээд, харин “*хаан*” хэмээх үг бичгийн дунд тохиолдох бүрт өмнө нь богино үг багтах хэмжээний зай үлдээн бичжээ. Мөр тэтгэвэл зохих үгийг ийнхүү бичих заншил лав Юань улсын үед байсныг Чан Ин Чжуй-гийн хөшөө (1335 он), Жигүнтэйн гэрэлт хөшөө (1338 он) зэрэг дурсгалаас үзэж болно. Сөүл хотын төвд орших Самжөндө-гийн (1640 оны) гэрэлт хөшөөний манж, монгол бичээсээс үзвэл, ийнхүү зай авч хүндэтгэлийн утга илэрхийлэх хэлбэр Умард Юань, Хойд Алтан улс болон Чингийн эхэн үед урьдын адил хэвээр хэрэглэгдэж байжээ. Харин хожим бараг

¹¹ “Дусал бинтгүй үсгийн данс” хэмээх нь Тэнгэрийн Тэтгэсэн хааны үед ялгаж өгсөн нэр. Судлаачид SHIU MAN TAN (Хуучин манж данс) гэсэн хятад нэрээр ихэвчлэн бичдэг. Уг дурсгалын чухам нэр нь “Ejehe Dangse”, монголчилбол “Ойллоо данс” буюу.

18 дугаар зууны үеэс манж монгол албан бичигт мөр тэтгэн бичдэг үгийг бус, харин мөр тэтгэхээс арай бага дэсээр хүндэтгэвэл зохих үгийн өмнө зай авч бичдэг болсон юм.

- Мөр дашлуулан бичих ёс энэ үеийн манж бичигт нэгэнтээ нэвтэрсэн байжээ. Гэхдээ энэ нь монгол, манж албан бичигт хятадаас нэвтэрсэн зүйл болно.

- Тус данснаас үзвэл, эхэндээ Хойд Алтан улсын үед манж нар монголчуудын нэгэн адил албан бичигтээ билгийн тооллын оныг хэрэглэж байжээ. Чингэхдээ, сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад оныг бичихдээ “хулгана жилийн..”, “бичин жилийн...” гэх мэтээр зөвхөн жил эрхтэнийг нь бичээд, жилийн эшийг нь бичээгүй байдаг бол 17 дугаар зууны эхэн үеийн манж албан бичигт “шар бичин жил” гэх мэтээр эш эрхтэнийг цугт нь тавьж байв. Удалгүй 1630-аад оны үеэс манж нар хятадын династийн /угсаа залгамжлах хаант төрийн/ уламжлалаар хааны оны цол тавьдаг болсон юм.

- Монголчууд ном бичигтээ сарыг монгол нэрээр нь хөхөө сар, хулан сар гэх мэтээр бичиж байсны зэрэгцээ Монголын хаант улсуудын үеэс¹² (13 дугаар зууны хоёрдугаар хагасаас) голдуу улирлын хэд дэх сар болохоор нь “хаврын эхэн сарын ...”, “өвлийн дунд сарын ...” гэх мэтээр бичих болсон бололтой. Үүний сацуу хожим багцаалбал, Юань улс мөхсөний дараахан Мин улстай харьцсан зарим бичгээс эхлэн сарыг бичихдээ хятад заншлаар улирлыг нь тавилгүй жилийн хэд дэх сар болохыг илтгэсэн дэс тоогоор тавих заншил нэвтэрч эхэлжээ. Манжийн эхэн үеийн албан бичигт Умард Юань улсын үеийн монголчуудын адил сарыг мөн тийнхүү хоёр янзын аль алинаар бичиж байжээ. Чин улсын үеэс манж албан баримтад сарыг зөвхөн дэс тоогоор тавих болсон юм.¹³

- Засвар оруулбарыг чагт тэмдэгээр заасан, албан баримт бүрийн өмнө бярга, эцэст дөрвөн цэг тавьж байсан зэрэг нь тухайн цагийн монгол бичгийнхтэй адил байна.

- Албан бичгийг агуулгаар нь дотор нь төрөлжүүлэн зүйлчилэхэд зүйл бүрийн эхэнд “нэгэн зүйл” хэмээх үгийг бичгийн дээд тараас илүү гарган бичих заншил байсан нь 17 дугаар зууны эхэн үеийн манж албан бичигт мөн тэр хэвээр уламжилжээ.

¹² Олонхи судлаач “Монголын эзэнт гүрний үе” гэж томъёолдгийг ийн бичлээ.

¹³ Манж нарын сарыг дэс тоогоор илтгэх заншил нь эртний Жүрчидийн Алтан улсын үеэс уламжилсан бөгөөд манжаар 11, 12 дугаар сарыг “омшон бияа, жоргон бияа” гэдэг нь эртний жүрчин хэлний үгс юм.

Ийнхүү “Дусал бинтгүй үсгийн данс”-ыг монгол албан бичгийн зүйлтэй харгуулан ажиглахад, манж албан бичигт тухайн үеийн монгол албан бичгийн хэв журмыг бараг хэвээр нь авч хэрэглэсэн байдал илэрхий байна.

Их Монгол улс хийгээд Монголын хаант улсуудын үед хааны захидал, зарлигийн бичиг зэргийн эхэнд “*Мөнх тэнгэрийн хүчинд, хааны сууд*” хэмээх титэм үг бичдэг байсан бол Умард Юань улсын үед хааяа албан захидлын өмнө бичиг номын эхэнд тавьдагчлан “*Оом сувасти шиддам*”¹⁴, “*Намо гүрү*”¹⁵, эцэст нь “*Мангаалам*”¹⁶ зэрэг өлзий өгүүлэх үгийг¹⁷ бичдэг байжээ. Өлзий өгүүлэх үг бичих нь албан бичгийн хувьд нийтлэг зүйл биш байснаас гадна шашны дэлгэрэлтэй холбоотой тул бурханы шашингүй манж угсаатны албан бичигт нэвтэрсэнгүй бололтой. “*Мөнх тэнгэрийн хүчинд, хааны сууд*” хэмээх мэтийн титэм үг, дөрвөлжин үсгээрхи зарлигийн бичгийн эцэст бичиж асан “*...хэмээж ёсгүй үйл бүү үйлдтүгэй, Үйлдвээс үл айх уу*” гэдэг тогтсон үг зэрэгтэй ойролцоо зүйл манж албан бичигт байдаггүй. Энэ нь 13-14 дүгээр зуун ба 17 дугаар зууны үеийн монгол албан бичгийн хоорондох ялгаа онцлог. Үүнийг монгол ба манж албан бичгийн ялгарах онцлог гэж хэлэх нь учир шалтгааны хувьд утгагүй билээ.

Мөн Умард Юань улсын үеийн албан захидлын эцэст захидал бариулсан элчийн нэр, өргөж буй бэлэг зэргийг бичдэг ёс байсан нь манж албан захидалд уламжлагдсангүй.

Харин монгол болон манж албан бичиг нь хятад албан бичгийн уламжлалтай ямар харьцаатай талаар судлаачид харилцан адилгүй саналтай байна. Г.Норовсамбуу гуай болон манай бусад судлаач монголчуудын албан бичгийн хэв журмыг 13 дугаар зуунаас нааш уламжилж ирсэнийг тэмдэглээд, өөр улс үндэстэний албан бичгийн нөлөө орсон эсэх талаар дурдсангүйг үзэхэд монгол үндэстний өөрийн бичгийн соёлын зүйл гэж үзсэн бололтой.

Японы Кобэгийн Их Сургуулийн профессор Хагихара Маморү Олон Улсын Монголч Эрдэмтэний IX их хуралд тавьсан илтгэлдээ¹⁸ Чин улсын үеийн монгол, манж албан бичгийг хятад албан бичгийн уламжлалтай харьцуулан судалж, улмаар энэ үеийн

¹⁴ Монголчилбол, “Сайн амгалан болтугай” хэмээх санскрит хэлний үг.

¹⁵ Монголчилбол, “Багшид мөргөмү” хэмээх санскрит хэлний үг.

¹⁶ Монголчилбол, “Өлзий хутаг орштугай” хэмээх санскрит хэлний үг.

¹⁷ Сумадиатна “Төвд Монгол дохионы бичиг”- тээ “Оом сувасти шиддам” зэргийг өлзий өгүүлэх үг хэмээн нэрийдсэн нь монгол бичиг номын соёлын уламжлалт нэр томъёо ажээ.

¹⁸ Хагихара Маморү, “Манж Чин Улсын Үеийн Монгол дахь Албан Бичгийн Хэв ба түүний Гарал Үүсэл” (The Due Form and its Origin of Official Documents in Mongolia during Manchu Ch’ing Period), The 9-th International Conference of Mongolists, 2006. 9-12 August, Ulaanbaatar,

гурван хэлний албан бичиг нь << 1. бичсэн хүн, 2. хүлээн авах хүн, 3. зорилго, 4. өмнөх бичгүүдийг давхар давхар шууд татаад гол өгүүллийг бичих, 5. байцаавал гэдэг үг, гол өгүүлэл, сүүлийн үг, 6. он сар өдөр >> гэсэн ижил хэв бүтэцтэй бөгөөд албан бичгийн тогтсон үгийн зүйл зэрэг нь 13-14 дүгээр зууны үе ба 16 дугаар зууны монгол албан бичигт байхгүй, тийм учраас “Манжийн үе болсны дараа Хятадын албан бичгээс Монгол ба Манж албан бичигт орсон байх ёстой” гэж үзжээ. Мөн тухайн нэг хэрэг явдлаар олон удаа харьцсан бичигт төдий хэмжээгээр эх сүүл залган цаас нэмж, хэргийг шийтгэхтэй холбогдсон дараа дараагийн зүйлийг бичдэг ёс эртний хятадын уламжлал болохыг батлан өгүүлжээ. Үнэхээр монгол албан бичгийн хэв журамд хятадаас нэвтэрсэн зүйл буй нь үгүйсгэх аргагүй ажээ. Гэвч, Чингийн үеийн Монгол дахь албан бичгийн хэв нь тэр чигтээ Манжийн эрхшээл эхэлснээс хойш хятад албан бичгээс орсон гэж үзэх нь хэтэрхий туйлшруулсан дүгнэлт болно. 13-14 дүгээр зууны үеийн монгол албан бичгийн хэвд ч мөн хятад албан бичигтэй адил нийтлэг зүйл байсан бөгөөд тэр нь хожмын монгол албан бичгүүдэд уламжлагдсаар ирсэн юм. 13-14 дүгээр зууны монгол хаадын зарлигийн бичгийг авч үзвэл,

1. титэм үг,
2. илгээгч,
3. хүлээн авагч,
4. гол агуулга,
5. тэнгэрийн ивээл дэх хааны сүр хүчнийг илтгэж, зарлигийг үл зөрчихийг сануулсан төгсгөлийн үг,
6. элчийн нэр,
7. огноо,
8. зарлиг буулгасан газар гэсэн бүтэц дараалалтай байна.

Үүнээс Умард Юань улсын үед 1 ба 5 –ийг бичиж байсан баримт алга. Гэхдээ, өнөө бидний үед олдож мэдэгдээд буй энэ үеийн баримт тун хязгаарлагдмал, ялангуяа 15-16 дугаар зууны үеийн албан бичгийн дурсгал, монголын хаадын зарлигийн зүйл уламжлагдаагүй тул ямар нэг дүгнэлтийг шууд хийх боломжгүй юм. Халхад 1691 оны үе хүртэл, Ойрдод түүнээс хойш ч Умард Юаний үеийн адил албан захидалд 1, 5-аас бусдыг нь бичсээр байсан билээ. Чингэсээр, манжийн эрхшээлд монгол бүрэн орсон үеэс эхлэн 6, 8 –ыг бичихээ больж, профессор М. Хагихара гуайн дурдсан хэв бүтэцтэй болжээ. Чухам энэ үеэс монгол ба манж албан бичгийн хэв бүтэц бараг бүрэн тохирох болсон байна. Үүнд, 13-14 дүгээр зууны үеийн монгол албан захидлын хэв бүтцээс 2, 3,

4, 7 буюу << илгээгч - хүлээн авагч - гол агуулга – огноо >> гэсэн үндсэн бүтэц дараалал нь хэвээр байна.

Иймд, манж албан бичгийн тухайд Хойд Алтан улсын үед анх үүссэнээсээ эхлээд монгол албан бичгийн уламжлалыг авсан бөгөөд улмаар Чин улсын үе болж ирэхэд хятад албан бичгийн онцлогийг тусган тогтсон үг зэргийг хуулбарлан хэрэглэх болсон; монгол албан бичгийн тухайд эртнээс хятад албан бичгийн зүйлтэй харилцан нөлөөлөлтэй байсан бөгөөд албан захидал нь дээр дурдсанчлан Монголын хаант улсуудын үед [1,2,3,4,5,6,7,8]; Умард Юань улсын үед (17 дугаар зууны эцэс хүртэл) [2,3,4,6,7,8]; Чингийн үед [2,3,4,7+ гол агуулгын эхэн ба эцэст бичдэг тогтсон үг] гэсэн хэв бүтэцтэй болж өөрчлөгдсөн гэж томъёолох нь зүйтэй байна.

Манж нар улсаа Дай Чин улс хэмээх болсон Дээд Эрдэмтийн тэргүүн (1636) оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Абахай хаан: << *ulus manu üliger qauli ülü medeküi čay-dur amabar ögülebesü ba bičig-dür bičibesü ba. degedü door-a-du kündü könggen-i ülü ilyan bülüge: edüge erten-ü üliger qauli-yi üjebesü. dorodus-un ayiladqal inu. öbere-e öber-e iyaburi-tai ajuyu: tegüber degedüs dorodus qoyar-i ilyan toytayabai: egün-ü qoyin-a bičig bariqu kümün boyda qayan-dur baribasü: bičig ergübe kemekü: čin wang. jiyun wang kiged: noyad-dur¹⁹ bolbasu -i medegülünem: sayid-dur bolbasu kelenem kemekü: qayan-u jarlay-i bičig-dür bičibesü ba: amabar ögülebesü ba: boyda qayan-u jarlay kemekü bui: qayan olan bügüde-dür jarlay bolbasu: jarlay bayulyaba kemekü: door-a-du kümün boyda qayan-dur üge medegülbesü ayiladqaba kemekü: ...yadayadu mongyol noyad-un elči-yi elči kemen ülü ögüleki: ed mal kürgejü irebesü: ed mal kürgejü mörgür-e irebe kemekü: jaryular-a irebesü. üge ayiladqar-a irebe kemekü: dotuyadu yadayadu jasad-un čin wang. törü-yin jiyun wang. törü-yin noyad-un qarilčan yabuqu elčid-i elči kemekü bui: čin wang jiyun wang: bay-a noyad tayiji nar-du elči ilegebesü mön elči kemekü: wang-dur ese oruysan: noyad tayiji nar-un elčid: čin wang. jiyun wang-dur yajum-a-yi kürgejü irebesü elči kemekü ügei: kürgejü iregsen kümün kemekü bui: čayaja kemekü ügei jasad kemekü bui: >> хэмээн зарлиг буулгажээ²⁰. Тус зарлигт гарч буй “улс ману үлгэр хууль үл мэдэх цагт” хэмээсэн нь хятад маягийн төрийн байгууламж, албан бичгийн заншлыг төдий л авч хэрэглээгүй байсныг дурджээ. “...амаар өгүүлбээс ба бичигт бичвээс ба дээд доодын хүнд хөнгөнийг нь үл ялган бүлгээ.” хэмээсэн нь төрөөс албан ёсоор тусгайлан тогтоосон журамгүй, харин тэр цагт нэгэнтээ хэвшил болоод байсан монгол албан бичиг, захидлын уламжлалыг аандаа*

¹⁹ Манжийн бэйл хэмээх үгийг 17 дугаар зууны үест бүр ноён хэмээн орчуулсан байдаг.

²⁰ Čing ulus-un Dotuyadu narin bičig-ün yamun-u Mongyol dangsa ebkemel-ün emkidkel. nigedüger emkidkel. Öbür Mongyol-un Arad-un keblel-ün qoriy-a. 2003., 73-76 дугаар талд.

урсгалаар дагаж байсныг хэлсэн хэрэг юм. Үнэндээ “зарлиг, бичиг өргөх, айлтгах” гэх мэт үгс монгол албан бичгийн уламжлалыг дагаад Хойд Алтан улсын үеийн манж албан бичигт ч байсан зүйл билээ.

Улмаар Чингийн төр бэхжихийн хамтаар манжийн архив, албан бичгийн хэрэг улам бүр төгөлдөржин хөгжив. Архив, албан бичгийн хэрэгт хамаарах тусгай хууль зүйлийн бичиг гараагүй боловч, зарим холбогдох журам заалт “Дайчин улсын бүгд хууль”-д бичигдсэн бөгөөд албан бичиг үйлдэхтэй холбоотой аль нэгэн асуудалд хандсан хаадын зарлиг удаа дараа гарч, түүнийг олон яам, газар оронд тархаадаг байв.

Монголын архив, албан бичгийн түүхэн дэх энэ үеийн нэг онцлог нь монголчууд харь үндэстний төрийн засаглалд байсан явдал юм. Хэдий тийм авч, Чингийн үед, төрөө дээдлэх монгол ёс, монгол соёл, бэлгэдлийг тусгасан монгол албан бичгийн уламжлалт хэв ёс эвдэрч, гээгдээгүйгээр үл барам, харин ч зарим талаар улам боловсрон хөгжсөн байдаг. Ингэхдээ, манж монгол албан бичгийн ёс нь зэргэд хөгжиж иржээ. Энэ нь нэг талаар, хэдий хятадын нөлөө байвч, үсэг бичиг хийгээд бичгийн соёл нь нэгэн эх үндэстэй, нөгөө талаар аль аль албан бичгийн хэрэг нь нэг л төрийн эрхээр хэрэгжиж байсантай холбоотой.

Чингийн үеийн монгол ба манж албан бичгийн онцлог нь өмнөх үеийн монгол албан бичгээс хэрэглэгдэх нэр томьёо, үг хэллэг, бичгийн хэрэгсэл, бичгийн хэв, бүтэц (өмнө дурдсан) зэрэг зарим зүйлээр ялгарахаас бус, харилцан зөрөх зүйл үгүй байна. Өөрөөр хэлбэл, Чингийн үеийн манж ба монгол албан бичиг нь ямар хэлээр бичсэн ялгаа байхаас бус, албан бичгийг үйлдэх хэв журмын хувьд ялгаагүй болно. Бийрээр бичих болсныг дагалдан бичгийн хэв өөрчлөгджээ. Өргөмжлөл, өчиг тангаргийн бичиг гэх мэт албан бичгийн шинэ төрөл зүйл гарч, айлтгал бичигт хаан улаан бийрээр цохолт хийх журам энэ үеэс бий болсон юм.

Мөн Чингийн үе болон Богд хаант Монгол улсын үед хүндэтгэх үүднээс хүний нэрийг хураангуйлан эхний үеэр бичдэг²¹, чингэхдээ ард нь ялимгүй зай үлдээдэг журам байв. Чингийн үеэс өмнөх монгол албан бичигт ийм журам байсан гэх баримт олдохгүй байна. Энэ нь манж нарын бий болгосон зүйл бөгөөд лавшруулбал хятад соёлын нөлөө бүхий зүйл мэт.

Магад хууль, хаадын богд сургаал, илтгэл шастир гэх мэт төрийн үйлтгүүлсэн “албан ёсны” судар бичгүүдээс аваад монголын хамаатай аливаа албан бичиг, тамга,

²¹ Хүний нэрийг Цэ ван, Да бэйс гэх мэтээр хураангуйлан бичдэгийг манжаар “hontoho gebu”, монголчилбол “хагас нэр” гэдэг.

өргөмжлөлийн үгийг цөм манж монгол хоёр хэлээр зэрэг үйлдэх буюу эсвэл хадмаллан бичдэг байв. Ингэхдээ 2-3 хэлний албан хэргийн тогтсон үгийн толь бичгийг ашиглан нэг мөр болгон жигдэлдэг байв.

XIII зууны үеийн монголын дурсгалт бичгүүдээс үзвэл, монгол албан бичгийн зүйлд хааны сүр хүчийг илтгэсэн, түүнд үл захирагдваас болохгүй гэдгийг тулгасан утга агуулгатай үгс байснаас биш хүндэтгэлийн үгийг хэрэглэсэн зүйл төдийлөн үгүй ажээ. Ер нь манжаас өмнөх үеийн монгол албан бичигт “зарлиг”, “дээд” гэх мэтийн цөөн үгийг эс тооцвол хүндэтгэлийн үг бараг байхгүй. Хожим Умард Юань улсын үед шашин ихэд дэлгэрч, төвд бичгийн хэлний нөлөө ихэссэний улмаас монгол бичгийн хэлэнд хүндэтгэлийн үгийг өмнөхөөс харьцангуй өргөн хэрэглэх болжээ. Тухайлбал, хүний бие эрхтний нэрийн зүйлд “*мутаp*”, “*бойв*”, “*үснир*”, “*лагшин*” гэх мэт ормол үгээс гадна “*мэлмий*”, “*тэргүүн*”, “*магнай*” гэх мэт монгол хүндэтгэлийн үгс олонтоо тохиолдох болсон байна. Улмаар Чин улсын үеийн монгол албан бичигт элдэв тогтсон тодотгол, чимэг үгээр хүндэтгэлийн утгыг илтгэх нь нэн өргөн дэлгэр болсон юм. Энэ нь нэг талаас бусад үндэстнийг илбэн тохинуулж, засаглах Манжийн бодлого, нөгөө талаас эдэн дагаж тал өгсөн шинжтэй тодотгол чимэг үг олонтоо хэрэглэх болсонтой холбоотой биз ээ. Жишээлбэл, Манжийн хаадын дараа өргөсөн цолыг бүтнээр нь бичвэл, Юань улсын хаадынхаас хэд дахин урт байдаг билээ. Гэхдээ тодотгол, чимэг, хүндэтгэлийн үгийг хэрэглэх нь дур зоригийн хэрэг бус, харин бичгийн утга агуулгыг харгалзаж хэнд, аль үгийг хэрэглэх нь зааг ялгамжаатай байсан юм. Энэ үеийн албан бичгийн боловсруулалтад харилцагч хоёр этгээдийн эрх тушаал, эрэмбэ дэс, ахас захасын ялгааг урьд урьдынхаас илүү нарийн тусгадаг болжээ.

17 дугаар зууны эхэн үеийн буюу манжийн эрхшээлд бүрэн автахаас өмнө монгол албан бичигт дээд эрх мэдэлтнээс доод эрх мэдэлтэнд хандахад “*бичиг илгээв*”, өөрөөс дээд эрх мэдэлтэнд хандсан бичигт “*өргөн барив*”, “*бичиг барихын учир*” гэх мэт зэрэг дэвийг харгалзсан хүндэтгэлийн үг хэрэглэж байв. Үүнийг Чин улсын үед нарийсган, хятад хэв заншлыг тусгасаар, албан хэргийг хөтлөхөд зайлшгүй баримталбал зохих 5-6 зүйлийн ялгавар бүхий тогтсон үгийг хэвшүүлсэн байна. Ийм тогтсон үгийг хааны зүйл, хэргэм зэргийн зүйл, яам жургааны зүйл, бичгийн зүйлийн гэх мэт байнга тохиолдох бусад нэр томъёо, үг хэллэгийн хамт нийтэд нь албан хэргийн тогтмол үг хэмээн нэрийдэж, хэрхэн зөв хэрэглэхийг тусгай толь бичгээр журамладаг байв. Ерөнхий нийдэм хэрэглэх албан хэргийн тогтмол үгийн толиос гадна яам,

жургаан (явдлын яам) тус бүрийн албан хэргийн тогтмол үгийн толь бичгийг хэвлүүлж байжээ.

XVII зууны үеээс эхлэн монгол, манж утга зохиолын хэлний хүрээ ихээхэн өргөжиж, үсгийн дүрэм тогтворжин утга зохиолын хэлний хэм хэмжээ улам боловсронгуй болсон юм. Үүнд, Манжийн хаадын зарлигаар монгол бичгийн мэргэдийг Бээжинд очуулж “Мэргэд гарахын орон” нэрт дохионы бичиг зохиолгон “Данжуур”-ыг монголчлуулсан, бусад үлэмжхэн хэмжээний монгол судар шастирыг Бээжинд барласан, түүнчлэн 2-5 хэлний орчуулгын болон тайлбар толь зэргийг зохиолгож байсан явдал зохих нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. XVII зууны үеийн монгол сурвалж, тэдгээрийн олон хувилбар эхэд нэг үгийн жигд бус бичлэг, ярианы хэлийг дагуулан дүрмийн бус бичиж байсан баримт цөөнгүй тохиолддог. Тэгвэл, хааны зарлигаар үйлдсэн түүхэн сурвалж, хууль цаазын болон албан бичгийн зүйлсийг үзэхэд зөв бичих зүй, найруулгын хувьд тун цэгцтэй байдаг. Албан хэргийг хөтлөн явуулахдаа тэдгээр “хааны зохиосон” толь бичиг хийгээд албан хэргийн тогтсон үгийн толийг мөрдлөг болгож бичдэг байв.

Чингийн үед нь зохих шаардлагын улмаас монгол албан бичгийг үйлдэх журам нарийсч, тодорхой загвар, үгийн сангийн хүрээнд баригдах болсон тул, урьд үеийн монгол албан бичигтэй харьцуулахад найруулгын хувьд ихээхэн хязгаарлагдмал болсон байна. Гэхдээ энэ нь албан бичгийн найруулгад харшлах зүйл биш юм. Тухайлбал, хэдий айлтгал, албан захидал боловч, тухайн бичгийн агуулга зорилгод нийцүүлсний зарим газар бас чөлөөтэй шүлэглэх, толгой холбох, уран дүрслэх зүйл байдаг байсан нь манжийн эрхшээлд орсны хойно үгүй болжээ. Хараахан манжийн эрхшээлд бүр орчихоогүй байсан үеийн зарим албан бичгээс эш татая. 1624 онд Манж болон Хорчины зүгээс Цахар ба Халхын эсрэг эвслийн гэрээ байгуулан тэнгэр газрыг тахиж, харилцан амалдаж өчиг өчихүйд, Хорчины Ууба тайжийн өчиг:

<< Дээр мөнх тэнгэрийн заяагаар²²

Тэнгэр газраа үр сацсанаас болсон

Тэнхэл үгүй (= тэнцэлгүй, хосгүй, М.Б.) хаадын төрөл олсон

Тэгш сэтгэлт гэгээн хаан

Түрвэлгүй учирсан Ууба хунтайж хоёр

Тэнгэрт өчиг өчмүй. >> хэмээн эхэлж байна.

²² Дээр мөнх тэнгэрийн заяагаар гэдэг энэ үг нь Төв Азийн нүүдэлчдийн тэнгэр шүтлэгтэй холбоотой бөгөөд Хүннүгийн үеэс аваад Түрэгийн хаант улсын үеийн албан бичигт ч иймэрхүү хэллэгийг хэрэглэсээр ирсэн гэж үзүүштэй.

Мөн 1684 онд Хошуудын Гүүш хааны ач Баатар эрх жононгоос Энх-Амгалан хаанд айлтгасан бичигт :

<< Онц хэлсэнгүйгээр хэнийг аван чадам

Омгийн эрхээр Сүмбэр уулыг яахин унагам

Оройгоос төрсөн хааны омгоор газарт унав эс гэл үү

Олны эзэн Чингис мэт хүчит эзний алтан хэрмийг түшин байнам буй >>²³ гэх мэтээр эхнээс аваад эцэс хүртэл бүгд 48 мөрөөр шүлэглэн бичжээ.

Чин улсын үед зарим талаар монгол, манж хэл бичиг хөгжиж байсан боловч, бас түүхийн хар мөр байсныг дурдууштай. Эдүгээ Бээжинд буй Чин улсын “Судар бичгийн хүрээлэн”-гийн архивын хадгаламж дахь “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир”-ын хэсэгт гагцхүү хятад бичгийн эх ноорог хадгалагдаж байна. Харин “Илтгэл шастир”-ыг зохиоход Монголын олон хошуу чуулганаас ирүүлсэн эх сурвалж, түүхийн материалаас нэг ч үлдээгүй аж. В.Хайссиг “Тэнгэрийн тэтгэсэн хаанаас монгол хүний гэрт байдаг бичиг материалыг бүгд цуглуулж, Бээжинд авчиртугай хэмээн зарлиг буулгаж, үлэмжхэн хэмжээний монгол түүх бичгийг хураан хааны ордны судар номыг хамаарах товчоонд аваачиж шатаагаад, ор мөргүй болгосон байна.” гэж тэмдэглэсэн байдаг. Үүнээс үзвэл, Умард Юаний үеийн бичгийн дурсгал тун ховор, Мин улс болон Хойд Алтан улсын хаадтай харьцсан цөөн тооны бичиг үлдэж хоцорсон байдгийн нэг шалтгаан нь Манжийн хаадын бодлоготой холбоотой байж болох юм.

Манж үсэг бичгийн нэг онцлог нь манж төдийгүй олон хэлний үгийг нарийвчлан тэмдэглэх бололцоотой буюу авианы галиг үсгийн үүргийг гүйцэтгэж чаддаг явдал юм. Иймээс ХҮШ зуунаас ХХ зууны эхэн хүртэлх үед монгол бичээч нар манж бичгийн дуудлага ялгах тэмдэгийг монголоор бичсэн зүйлдээ хэрэглэсэн нь цөөнгүй байдаг. Манж хэлнээс дам монголчилсон эртний хятадын сонгодог зохиолууд, монгол түүхийн сурвалжууд, архив албан бичгийн баримтад харь хэлний оноосон нэрийн зүйлийг манж үсгээр тодлон бичих явдал энгийн хэвшмэл хэрэглээ болж байжээ. Тэр ч байтугай, монголчууд төвд хэлээрхи сангийн судар мэтийг ч манжаар галиглан тэмдэглэсэн байдаг.

Монголоос бичгийн соёлыг нь авсан манж үндэстэн тэрхүү бичгээ төрийн бичиг болгон Чин улс даяар албан хэргийг хөтлүүлж байсан явдал бол монгол, манж албан бичгийн соёл зэрэгцэн хөгжих бодот нөхцөл байдлыг бий болгожээ.

²³ Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс. 4 дүгээр боть. 43-49 дүгээр талд.

1. Дусал бинтгүй үсгийн данс
 2. Дусал бинтгүй үсгийн данс
 3. Дусал бинтгүй үсгийн данс
 4. Дусал бинтгүй үсгийн данс
 5. Дусал бинтгүй үсгийн данс
 6. Дусал бинтгүй үсгийн данс
 7. Дусал бинтгүй үсгийн данс
 8. Дусал бинтгүй үсгийн данс
 9. Дусал бинтгүй үсгийн данс
 10. Дусал бинтгүй үсгийн данс

“Дусал бинтгүй үсгийн данс”-ны нэгэн хуудас. “han” /хаан/ хэмээх үгийн өмнө 5 удаа зай үлдээн бичжээ.

Ном зүй

1. Баярсайхан М, “Манж бичгийн хөгжлийн зарим асуудалд”; “Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг”, Боть ХҮИ (160), Улаанбаатар, 2000, 92-100.
2. Воробьев М.В, “Культурные взаимосвязи между монголами и чжурчжэнями (цзинцами) в XII-XIII вв; Литературные связи Монголии”, Москва, 1981, 23-38 с.
3. Dayicing gürün-i Dotuyadu yamun-u Mongyol biçig-ün ger-ün dangsa, Öbür Mongyol-un Arad-un keblel-ün qorigu-a, 2005, 22 боть.
4. Евсюков В.В, “Чжурчжэни и их отношения с Мин (XV в.)”; “Восточная Азия и соседние территории в средние века”, Новосибирск, 1986, 64-79.
5. Кузнецов В.С, “Взаимоотношения чжурчжэней и Маньчжурского государства с Кореей (вторая половина XV-первая четверть XVII в.)”; “Восточная Азия и соседние территории в средние века”, Новосибирск, 1986, 79-86.
6. Ли Бао-Вэнь, Намка нар, “ХҮИ зууны тэргүүн хагасын монгол, манжийн харилцаанд холбогдох баримт бичгүүд”, Улаанбаатар, 2004. (Кирилл үсэгт буулгаж тайлбар хийсэн Ц.Төрбат, Д.Энхцэцэг, хянан нягталсан Г.Дашням)
7. “Монгол улсын архивын албаны түүхэн хөгжилт, орчин үе” Улаанбаатар, 2001.
8. Норовсамбуу Г, “Монголын эрт эдүгээгийн төрийн бичиг, архивын товчоон”, Улаанбаатар, 2003 он.
9. Норовсамбуу Г, “Монголын архив, албан хэрэг, түүний бичгийн хэв”, Улаанбаатар, 1975.
10. Tongki fuqa aqū hergen-i dangse.
11. Хагихара Маморү, “Манж Чин Улсын Үеийн Монгол дахь Албан Бичгийн Хэв ба түүний Гарал Үүсэл” (The Due Form and its Origin of Official Documents in Mongolia during Manchu Ch'ing Period), paper for 9-th International Conference of Mongolists, 2006. 9-12 August, Ulaanbaatar,
12. Цэвэл Я, “Монгол албан бичгийн уламжлал”, Улаанбаатар, 1959.
13. Čing ulus-un Dotuyadu narin biçig-ün yamun-u mongyol dangsa ebkemel-ün emkidkel. Öbür Mongyol-un Arad-un keblel-ün qorigu-a, 2003, 8 боть.
14. Шагдарсүрэн Ц, “Монголчуудын утга соёлын товчоон”, Улаанбаатар 2004.

RESUME

As accepted, the Manchurian literature has taken its origin from the official writings in the Mongolian language and script.

The earliest inherited monument of the written Manchurian is a collection of important state-running papers and documents under the name "Ejehe dangse" /Jiu Man Tang/. An observing of the items in this collection clearly shows that the procedure and style of the Mongolian official papers in the period of the Northern Yuan Dynasty are copied in them almost wholly. Regarding the Manchurian official paperwork it can be traced that since the origin during the Later Jin Dynasty it had been following the traditions of the Mongolian official paperwork till up-to the Qing period when the procedures of the state-running paperwork were over reviewed in number of times by the Khans' orders in accordance with the traditional Chinese style and established word expressions.

Concerning the Mongolian official paperwork the author asserts that since the earlier times it had a relationship to the Chinese tradition and in spite of some changes during the periods of the Mongolian states and the Northern Yuan Dynasty, as well as in the Qing period it remained the same in its basic form and structure.

The Mongolian and Manchurian official papers in the Qing period coincide in their form and structure and developed in parallel.